

Бүтээгч Эзэн бүтээлээ санах болно




Ариун бичвэрүүдийн дагуу Ертөнцийн Эзэнтэй хамт алхдаг хүмүүс нас барсныхаа хойно Түүнийг магтдаггүй, санадаг ч үгүй, юу ч мэдэхгүй, мэдрэхгүй билээ. Хүн бол махбод, амин сүнс хоёроор бүрдсэн “амьд сэтгэл” бөгөөд үхлээр махбод, амин сүнс хоёр нь салахад юм мэдэрдэг, сэхдэг сэтгэл нь ч үгүй болдог учраас тэр. Хүн бүр үхэхэд хүрэх шалтгаан бол өвөг эцэг Адамаас өвлөж авсан

“уламжлалт үхэл” юм. Гэхдээ сайхан мэдээ нь болохоор хүн үхлээр оршихоо больсон ч гэсэн үхэл юм бүхний эцэс биш. Есүс Христийн загалмай дээр хийсэн ажлын ачаар хүн бүр дахин амилах бодит найдлагатай. Энэ бүхнийг бид өмнөх хэдэн нийтлэл дээрээс олж харсан.

Библийн хамгийн эртний бичвэр гэдгээрээ алдартай «Иов» ном эдгээр үнэнийг гайхалтайгаар батална. Иов израйльчуудыг Египет оронд байх үед амьдарсан, Едом нутгийн хаан байсан бололтой.¹

- 1 Иовын нутгыг Уз гэдэг (Иов 1:1). Абрахамын ач Иакоб гэр бүлээрээ Канаан оронд буцан ирж амьдрахад ах Есав нь Иордан голын цаана буй Сеирийн уулархаг нутагт нүүж Едомчуудын эцэг болжээ. Есавын хөвгүүд ба ач нар Едомчуудын тэргүүлэгч болжээ. Дээр нь Сеирийн хөвгүүд тус нутгын иргэд болох хоричуудын тэргүүлэгчид байв. Сеир нутгын хэсгүүдийг тэдгээр тэргүүлэгчийн нэрээр нэрлэсэн. Иовын нутгийн эцэг Уз бол Сеирийн ач байсан юм (Эхлэл 36; Гашуудал 4:21-г үзнэ үү).





Мөнхийн Эзэний гэрчилснээр “газар дэлхий дээр Иов шиг гэм зэмгүй, шулуун шударга бөгөөд Надаас эмээж, бузар муугаас хол явдаг хүн алга” байв (Иов 1:1,8). Гэвч Сатаны бодлоор Иовын Их Эзэнээс эмээдэг нь чин сэтгэлийнх биш, эрх ашгаа бодсноос үүдэлтэй гэжээ. Тийм биш гэдгийг үзүүлэхийн тулд Их Эзэн Иовыг шалгах зөвшөөрлийг Сатанд өгчээ.

Тэр үеэс эхлэн Иов дэндүү хэцүү үеийн дундуур явсан. Хамаг юмаа бүү хэл, арван хүүхдээ хүртэл алдав. Иов энэ хэцүү байдалдаа гутран, үхлийн тухай их бодсон.

(Үргэлжлэл)

Иов бол “дорнын хүмүүсийн дунд хамгийн агуу нь байжээ” (Иов 1:3). Иакоб Иордан голыг гатлаад “дорнынхны нутагт” орж ирсэн билээ (Эхлэл 29:1). Үүнээс дүгнэхэд Иов Иордан голын цаана орших нутагт нутагласан тэргүүлэгч байсан. Дорнын хүмүүс мэргэн ухаанаараа мөн алдартай байсан юм (1 Хаад 4:30).

Иов Едомын нутагт оршин суудаг бол найз Елифаз нь Есавын ач Теманы үр удам, эсвэл теманчуудын нутгийн хүн байв (Иов 2:11; Эхлэл 36:15,34). Найз Билдад нь Шухын хүн бөгөөд Шух Абрахамын сүүлчийн эхнэрээс гарсан бага хүү байсан бололтой (Иеремиа 49:8; Эхлэл 25:2). Залуу найз Елиху болохоор Бузын хүн байсан бөгөөд Буз нь Теманы адил Есавын үр удам байлаа (Иов 2:11; Иеремиа 25:23). «Септуагинта» хэмээн эртний орчуулгад хавсаргасан хавсралтын дагуу Иов бол Едомын хоёрдахь хаан байсан Иовав мөн (Эхлэл 36:33). Эхнэр нь бол Бозра нутагт төрсөн Есавын гуч байв. Гурван найз нь өөртэй нь ижилхэн байр суурьтай хаадууд гэж мөн тэнд тэмдэглэжээ.

Иов хаан хүн байсантай таарах хэдэн үгийг ч өөрөө хэлсэн. Иов өөрийгөө хаад, ноёдын хамт оршуулагдана байх гэж бодсон (3:13-15). Түүнийг “хотын их үүдэн дээр” болдог хуралд “суудлаа эзлэх цагт” ноёд хүртэл “үг яриагаа хазаарлаж, аман дээрээ гараа тавьдаг байлаа” (29:7-11). Хотын үүдэн дээр Иов шударга шүүх явуулахад бүгд үгийг нь хүлээж, “тус зөвлөгөөг нь дуугүй авдаг байлаа”. Иов өөрийгөө “хүчит дайчдынхаа дунд заларсан хаан мэт залардаг” байснаа дурсдаг (29:12-25).



Бүтээгч Эзэнд
их гомдсноо
илэрхийлсэн ч
гэсэн, Иов
өөрийг нь
Аврагч бий
гэдгээс
зууралдан байж,
Бүтээгч Эзэндээ
үнэнч хэвээр
үлджээ. Эцэст



нь Их Эзэн “Миний тухай зөвийг ярьсан” гэж Иовыг сайшаажээ (Иов 42:7). Мөн хожим Езекиелд Иовыг онцгой зөвт хүн байсан гэж магтдаг (Езекиел 14:14). Тиймээс энэ нийтлэлдээ амьдрал, үхэл ба дахин амиллын тухай Иов юу гэж хэлсэн, ямар найдлагатай байсныг авч үзье.

Амьдрал ба үхлийн талаар Иов найзуудынхаа хамт бусад Бичвэртэй нийцэх үндсэн үзэлтэй байсан. Үхэл буцалт болохыг тэд лав мэдсэн. Тухайлбал:

“Бурханы Сүнс намайг бүтээсэн бөгөөд Төгс Хүчит Нэгэний амьсгал надад амь өгдөг билээ” (33:4). “Хэрэв Тэрбээр... хүмүүнд өгсөн сүнс ба амьсгалаа Өөртөө буцааж хураавал... хүн төрөлхтөн шороондоо буцах байсан”


(34:12-15; мөн 10:9). Үхлээр хүний “сэтгэл нь” хүртэл үхдэгт тэд итгэдэг байв (Иов 36:14; еврей: “сэтгэл”, СМО: “амь нь”, АБ: “тэд”).

Үхэл бол буцалт.

* Бие нь газар шороонд буцдаг.

* Сүнс нь Бүтээгч Эзэн рүү буцдаг.

* Сэтгэл нь эргээд “үл мэдэх байдал”-д ордог.



Өөрийгөө үхлээ гэж бодож байхдаа Иов гаслан:
“Нас минь нэхмэлчний зүүнээс ч хурдан өнгөрч
Найдлагагүйгээр ингээд би төгсгөлдөө хүрчээ...
Намайг харагч Түүний нүд дахиж намайг харахгүй.
Намайг харъя гэвэл би байхгүй болсон байна.


Үүл замхран одохын адилаар

**Үхэгсдийн орон руу буугсад эргэж гарахгүй [еврей:
өгсөхгүй]...**

...одоо би шороонд хэвтэх болно.

Хайж Та намайг эрэвч би алга болсон байна” гэв (Иов
7:6-21).

Итгэгч хүн нас
эцэслэхдээ Бүтээгч
Эзэн дээрээ очдоггүй,
Үхэгсдийн оронд
буудгийг Иов
ойлгосон. Очих гэж
буйгаа тэр оронг Иов
“Харанхуйн нутаг,
үхлийн хар сүүдэр...
түнэр харанхуй, эмх
цэгцгүйн орон” гэж
тодорхойлов (Иов
10:20-21). “Ор дэрээ
засдаг” тэр орон
булшийг хэлдэг нь



тодорхой (17:13-14). Энэ орон бол бөө нарын
ярьдаг доод тэнгэрт буй “харанхуйн орон” биш гэсэн
үг. Мөн бөө нарын тэнд уулздаг олон сүнс үхсэн
хүнийх биш гэдэг нь ойлгогдож байна.



Нас барсан итгэгчид лав бусдын адил шороонд буюу булшинд хэвтдэгийг Иов баталдаг. Үхэгсэд Бүтээгч Эзэний хувьд ч “байхгүй болдог”, “алга болдог” бөгөөд “эргэж гарахгүй”. Энэ сүүлийн үг еврейгээр “өгсөхгүй” гэсэн утгатай учраас мөн “дээш хөөрөхгүй”, “тэнгэрт халихгүй”, “өөд болохгүй” гэж орчуулж болно.


Энэ үг үхэгсдийг тэнгэрийн улсад очдоггүйг давхар батална. Үүнчлэн Есүс Их Эзэн: “Хүний Хүүгээс өөр тэнгэрт дээш гарсан хүн нэг ч үгүй” гэжээ (Иохан 3:13).



Сэдэвт маань хамаатай Иовын нэг яриаг хамтдаа чагнаая:

**“Эхээс төрдөг хүн бүхний амьдрал
Богино хэрнээ бэршхээлээр дүүрэн ажээ.
Цэцэг мэт дэлгэрэвч хагдарч хорчийдог.
Сүүдэр мэт хулжаад, арилж оддог.
Ийм нэгэн дээр Та мэлмийгээ тогтоож
Энэ бие дээр минь шийтгэлээ буулгалаа гэж үү?
Хэн бузраас цэврийг гаргаж чадах вэ?
Хэн ч чадахгүй!”** (Иов 14:1-4)

Энэ үгнээс харахад Иов хүний дотор “бузар” юм байдгийг мэдсэн. Энэ бол “төрөлхийн үхэл” ба “үхлийн хатгуур болох нүгэл” билээ.



Тийм ч учраас төгс алдаагүй хүн нэг ч байхгүй, бүгд амийн хүчээр дутагддаг, сул дорой учраас амь амьдрал нь богино, бэршээлээр дүүрэн. Цааш яриаг нь чагнахад (Иов 14:5-10, 14):


**“Хүмүүний өдрүүд нь тогтоогдсон.
Хоног саруудын тоо нь Танаас өгөгдсөн.
Хэмжээ хязгаарыг нь Та тогтоосон хойно
Хэн ч түүнийг даван гарч чадахгүй...
Харин модонд бол найдвар бий.
Цавчуулсан ч дахиад ургана.
Навч нахиа нь тасралтгүй соёолно...
Харин хүн бол үхнэ, өнхрөөд өгнө.
Тэрээр дуусна,
тэгээд хаана байна вэ? (...)
Хүн үхлээ гэхэд
эргээд амьдрах уу?”**

Бүтээгч Эзэний тогтоосон үхлийн өөдөөс харсан Иов яг зөв асуулт тавьдаг:

“Үхэж дууссан хүн хаана байна вэ? Хүн үхлээ гэхэд эргээд амьдрах уу?”

Модыг огтолсон ч үндэснээсээ дахин ургаж нэг ёсондоо амилах нь бий. Модонд нэгэнт найдвар байхад хүнд найдвар байхгүй гэж үү?






Бүтээгч Эзэн бүтээлээ санах болно □ 7

**“Нуурын ус татарч, голын ус ширгэх мэт
Нурж унаад хүн дахиж эс босно.
Тэнгэр үгүй болох хүртэл босохгүй.
Тэрээр нойрноосоо сэрэхгүй.
Үхэгсдийн оронд Та намайг
нуучихдаг ч болоосой.
Уур хилэнгээ өнгөртөл
намайг хав дарчхаад
Товлож тогтоосон цагтаа л Та
намайг санаасай.” (Иов 14:11-13)**

Ертөнцийн Эзэний үгийг сайн мэдэхгүй хүнд Иовын дээрх үгэнд найдвар харагдахгүй байх. Гэтэл бид Бичвэрийг Бичвэрээр тайлж сурах хэрэгтэй. Иов тодорхой хэмжээний эш үзүүлэгч байсан нь энэ үгнээс нь мэдэгдэж байна. “Тэнгэр үгүй болох” гэсэн нь “хэзээ ч үгүй” гэсэн утгатай хэллэг биш. Бичвэрийн дагуу шинэ тэнгэр, шинэ газар бүтээгдэхийн өмнө өнөөгийн тэнгэр үгүй болох ёстой.

“Тэнгэр үгүй болох”-ыг дурдсан Иовын зөгнөлийн биеллийг Иохан харжээ. Үүнд (Илчлэл 20:11-12):






“Цагаан өнгөтэй агуу сэнтий болон дээр нь Залрагчийг² би харав. Түүний дүр төрхөөс газар, тэнгэр зугтсан бөгөөд тэдэнд байх газар эс олдов. Их, бага үхэгсдийг³ сэнтийн өмнө зогсохыг би харлаа. Номууд дэлгээстэй байв. Өөр нэг ном дэлгээстэй байсан нь амийн ном аж. Үхэгсэд үйлсийнхээ дагуу эдгээр номуудад бичигдсэнээр шүүгдэв.”

“Тэнгэр зугтан үгүй болох” тэр үед хүн төрөлхтөн үхлийн нойрноосоо сэргэж, шорооноос босох болно гэсэн зөгнөл Иовын үгэнд агуулагдсан байна.

2 Энэ бол Есүс Христ. Үйлс 17:31-32г үзнэ үү.

3 Энд “хадгалал” гэж нэрлэж болохуйц хэлний дүрслэх арга хэрэглүүрийг ашигласан байна. “Хадгалал” хэмээх дүрслэх хэрэглүүрийн энгийн нэгэн жишээд бид “машин унах” тухай ярьдаг. Машиныг залж явуулахыг илэрхийлсэн оновчтой үг бидэнд байхгүйн улмаас машин гарахаас өмнө түгээмэл унаа байсан моринд хэрэглэдэг үгийг бид хадгалж ирсэн. “Жолоо” гэдэг үг мөн адил морь унаж байснаас гаралтай үг. Ийм маягаар шинэ нөхцөл байдалд ч гэсэн хуучин нэр томъёогоо хадгалж хэрэглэхийг “хадгалал” гэж нэрлэнэ. Ийм л утгаар “суунги нь алхаж, дүлий нь сонсож” (Матай 11:5), “үхсэн хүн босоод ярьж эхлэв” (Лук 7:15). Дүлий хэвээрээ ч сонсдог болсон зэрэг утгагүй зүйлийг хэлээгүй нь мэдээж. Энэ хүмүүс алхаж, сонсож, босч явахаасаа өмнө суунги, дүлий, үхсэн байсан тэр л хүмүүс болохыг цөөн үгээр илэрхийлэхэд хадгалал хэмээх дүрслэх хэрэглүүрийг ашигласан. Үүнчлэн Иоханы үзэгдэлд “үхсэн хүмүүс зогсож” байгаа гэсэн нь тэднийг үхсэн хэвээр болохыг хэлээгүй, харин дөнгөж сая амилж босохоосоо өмнө үхмэл байсныг илэрхийлнэ. “Анхны амилалтанд багтаагүй, “үхэгсдээс үлдсэн нь мянган жилийг дуустал амилсангүй.” (Илчлэл 20:4-5). Үлдсэн эдгээр хүмүүс эцэст нь амилж, цагаан сэнтийн өмнө зогсжээ. Тэд шүүгдэхээс өмнө заавал амилаад булшнаасаа гарч ирэх нь Иохан 5:25-30-с ч гэсэн тодорхой байна.



Тэнгэр үгүй болох нь Бүтээгч Эзэний уур хилэнтэй холбоотой гэсэн. Тэнгэр үгүй болохын өмнө “Мөнхийн Эзэний хилэнгийн өдөр” (Исаиа 13:9,13; Зефаниа 2:3) үнэхээр энэ дэлхий дээр болж өнгөрөхийг Иохан мөн олон үзэгдлээр харсан («Илчлэл» ном).

Энэ бүхнийг Иов бүдэг бадаг харжээ. Бүтээгч Эзэний уур хилэн өнгөртөл үхэгсэд Үхэгсдийн оронд хадгалаастай байх нь учиртай. Тэнд Бүтээгч Эзэн дэлхийг цөлмөх Өөрийн уур хилэнгээсээ үхэгсдийг нууж хамгаалахыг Иов ухаарсан. Энэ нь Үхэгсдийн орон там биш болохыг маш тодохой харуулдаг бас нэг баримт юм.



Иов үхлийг “цэргийн албанаас халагдах” мөч мэтээр үзсэн бөгөөд дараа нь үхлээс ч гэсэн “халагдан” чөлөөлөгдөх найдлагатай байжээ. Үүнд (Иов 14:13-14):

**“Товлож тогтоосон цагтаа л Та
намайг санаасай.**

Хүн үхлээ гэхэд эргээд амьдрах уу?

Хүнд хөдөлмөрөөр дүүрэн

бүхий л амьдралдаа

Халаа минь ирэхийг би хүлээнэ...”



Энэ бол үнэхээрийн гайхалтай үг. Бүтээгч Эзэн, үхээд үгүй болсон бүтээлээ санахгүй гэж үү? Өөрийн гарынхаа бүтээлээ Тэр яаж мартаж билээ дээ! “Тэр үед Өөрийн гараар бүтээсэн хүнээ үзэхийг Та хүсэхгүй гэж үү?” (Иов 14:15; ББ).

Бүтээл нь Өөрт нь үгүйлэгдэх учраас Бүтээгч Эзэн Үхэгсдийн оронд “нууж хадгалсан” хүмүүс рүүгээ тэмүүлж, тэднийг амилуулах нь гарцаагүй. Иймд Иов “би хүлээнэ” гэж



итгэлтэйгээр хэлж чадсан. Есүс ба элч нарын хэрэглэдэг байсан «Иов» номын грек орчуулганд Иов бүр “Би дахин оршихоо хүлээх болно” гэжээ.⁴

“Хэрэв хүн үхвэл дахин тэрээр амилах уу?” гэсэн асуултанд Иов өөрөө хариулжээ (Иов 14:14-15; АБ):

**“Та дуудах бөгөөд Танд би хариулна,
Та мутрынхаа бүтээл рүү тэмүүлэх болно...”**

4 Иов 14:14 дэх “хүнд хөдөлмөр дүүрэн амьдрал”-ыг АБ-д “зүтгэл” гэж орчуулсан. Тэр үг “цэргийн алба” гэсэн үндсэн утгатай. “Халаа” гэж орчуулсан үг цэргээс гарч чөлөөлөгдөхийг хэлэх агаад “сайн тийш өөрчлөгдөх” гэсэн үйл үгнээс гаралтай. Тус үйл үг мөн “соёолох” гэсэн утгаар өвс ургамалд ашиглагддаг (Дуулал 90:5). Энэ бол дахин амиллын дүр зураг мөн (1 Коринт 15:36-38). Иймд эртний грек орчуулга болох «Септуагинта» (товч: LXX) энэ ишлэлийн хоёрдахь хэсгийг шууд “Би дахин оршихоо хүлээх болно” хэмээн орчуулсан. Иов ном маш эртний еврей хэлээр бичигдсэн учраас олон тохиолдолд ойлгоход бэрх бөгөөд тиймээс орчуулгууд хоорондоо зөрдөг.



Бүтээгч Эзэн дуудахаар бүтээл нь заавал хариулна. Хүн үхэхдээ оршихоо больдог боловч амьдралынх нь түүх арилахын аргагүй. Үүнчлэн Их Эзэн хүний хувийн онцлогийг үхснийх нь хойно ямар нэгэн байдлаар хадгалдаг.

Эс тэгвээс Их Эзэн чухам “хэн”-ийг дуудах вэ? Чухам “хэн” Их Эзэний дуу хоолойг сонсох билээ? Энэ талаар Есүс Их Эзэн Өөрөө зөгнөжээ. Үүнд (Иохан 5:25-30; Илчлэл 20:4-6):

“Үхэгсэд Бурханы Хүүгийн дууг сонсох цаг ирж байгаа... Сонссон нь амилах болно... шүүлтийг гүйцэтгэх эрх мэдлийг [Эцэг Хүүдээ] өгөв... Булшинд байгчид бүгдээрээ Түүний дууг сонсон гарч ирэх цаг ирж байна. Сайныг үйлдсэн нь амийн амилалд, муу муухайг үйлдсэн нь ялын амилалд байх болно. Би юуг ч Өөрөөсөө үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх бөгөөд шүүлт минь шударга...”



Иов алсын ирээдүйг бүр эрт цагаас, нэг ёсондоо холын холоос л харсан учраас энэ хоёр амиллыг ялгаагүй. Есүс Их Эзэн ч гэсэн мянган жилийн зөрүүтэй энэ хоёр амиллыг ганц явдал мэтээр ярьсан.



Ямартай ч дахин амилахдаа Бүтээгч Эзэндээ гэмгүйд тооцогдох найдвар Иовд мөн байсан нь цаашын ярианаас нь ойлгогдоно. Тухайлбал (Иов 14:16-17):

**“...Тэгвэл Та алхмыг минь тоолохгүй.
Тэгээд Та нүглийг минь тоолж тооцохгүй.
Хэрэг зөрчлийг минь
шуудайд битүүмжилнэ.
Хилэнц нүглийг минь хааж халхална.”**



Иов Их Эзэнд “гэм зэмгүй, шулуун шударга” гэдгээр дүгнүүлсэн боловч өөрийгөө хэзээ ч гэм нүгэлгүй хүн гэж хэлээгүй. Харин ч “алдаа зөрчлийг минь, хилэнц нүглийг минь” уулчлан зайлуулахыг Их Эзэнээс гуйжээ (7:21). Гэм нүгэл арилахад заавал төлөөс төлөх шаардлагатай, тэр төлөөсийг өргөлөөр өргөх зууч бас хэрэгтэй гэсэн

ойлголт Иовд байсан (1:5). Өөрт нь тийм Зууч байдагт Иов итгэжээ. Үүнд (Иов 19:25):

**“Миний Өмгөөлөгч амьд гэдгийг
би мэдэж байна!
Тэрбээр эцэст нь миний төлөө
шороон дээр зогсох болно...”**



“Өмгөөлөгч” гэж орчуулсан үг «Рут» номд “зольж авагч” гэснээр гарч байна (Рут 2:20; 4). Эртний хуулийн дагуу хамгийн ойрын хамаатан нь болох зольж авагч бэлбэсэн эхнэр, өнчин хүүхдийг гэр бүлдээ авч халамжлах ёстой.



Дээр нь, хүн ядуурснаас болоод эзэмшил газраа, өөрийгөө ч зарахад хүрвэл зольж авагч нь түүнийг газрынх нь хамт эргүүлэн худалдан авах эрхтэй, бас үүрэгтэй. Ингэснээр зольж авагч нь тухайн хүнийг ч чөлөөлөн, ураг төрлийнхөө эзэмшил хөрөнгө, ашиг сонирхлыг ч хадгалж үлдэх аж (Левит 25-г үзнэ үү). “Өмгөөлөгч”-ийн бас нэгэн үүрэг бол үхэгсдийн төлөө шударга ёс авчрахад оршино (Тооллого 35, АБ: “цусан өшөө авагч”). Үүнчлэн бүх төлөөсийг төлж, өөрийг нь гэм ба үхлийн боолчлолоос зольж аван чөлөөлж, шударга ёсыг гүйцэтгэх хамгаас ойрын Нэгэн байдгийг Иов мэдсэн.



Иовын үед хүмүүс Христийн загалмайд төлсөн төлөөсийн тухай мэдээгүй ч, Аврагч Эзэн биеэрээ энэ дэлхийд ирж, хүмүүсийг гэм ба үхлээс аврах тухай ойлголт эхнээсээ байсан байна. Энэ талаар Их Эзэн эртний өвөг эцгүүдэд илчлэлт өгчээ.⁵

-
- 5 Эртний иудейчүүдийн бичсэнээр Адамаас Аарон хүртэлх 40 дөхөм өвөг эцэг бүгд Ертөнцийн Эзэнээс үг авсан эш үзүүлэгч бөгөөд үр удамдаа зориулж гэрээс бичиж үлдээв. Үүнийг эрдэмтэд домог төдий гэж үздэг байсан. Енохын ном 1773 онд Этиопоос эрдэмтдийн гарт ирсэн аж. Гэвч Аврагч Эзэний тухай олон зөгнөл нь «Шинэ гэрээ»-ний агуулгатай дэндүү сайн таарсан учраас тус номыг Христийн үеийн дараа л бичсэн уран зохиол гэж эрдэмтэд үзсэн. 1666 онд гарсан Армен Библид “Иакобын 12 хүүгийн гэрээс” хавсаргасан байна. Үүнд агуулсан Аврагч Эзэний тухай зөгнөсөн зөгнөл мөн адил Есүс Христэд дэндүү сайн таарсан учраас эрдэмтэд тус гэрээсийг бас л болсон явдлын хойно зохиосон хуурмаг зохиол гэж үздэг байв. Гэтэл 1947 оноос эхлэн Мөхсөн тэнгисийн эргэн дээрх Кумраны 12 агуйгаас 20-р зууны хамгийн том нээлт болох эртний иудей номын санг олжээ. Шавар вааранд хадгалагдсан тэр номын сангийн хуйлмал ном ба эдгээрийн үлдэгдэл ихэвчлэн МЭӨ үеийн эхний гурван зуунаас үүдэлтэй. Энэ номын санд Иаковын арван хоёр хүүгийн гэрээсээс таван нь лав олдсон. Үүнээс ч илүү эртний ном гэвэл, Адамын ач Енош, Енох, Ноагийн эцэг Ламех, Ноа, Аврахам, Иаков, Леви, Левигийн хүү Кохат, Левигийн ач Амрам, Амрамын хүү Аарон нарын үлдээсэн гэрээс олдсон. Нийт 19 гэрээсийн үлдэгдэл олдсон байна. Хамгийн гайхалтай нь, эдгээр гэрээс ёс суртахууны олон заавраас гадна Аврагч Эзэн ирэх тухай олон зөгнөлийг агуулжээ. Эдгээрийн дундаас хамгийн чухал нь болох Енохын зөгнөж бичсэнээр Аврагч Эзэн Ертөнцийн Эзэний Хүү ч, “Адамын Хүү” ч байх болно (АБ: “хүний Хүү”). Тэрээр хүмүүсийг аврахын тулд цусаа урсгаад дахин амилах агаад энэ дэлхийд биеэрээ эргэн ирж, Өөрт нь найдвараа тавьж итгэсэн хүнийг аврах болно. Кумраны агуйгаас олдсон тэдгээр гэрээс бүхий хуйлмал номын үлдэгдэл нь эдгээр зөгнөлийг яах ч аргагүй Христийн өмнөх үеэс үүдэлтэй болохыг баталсан юм.



Тэдгээр эртний зөгнөлийг Иов мэдсэн нь гарцаагүй. Их Эзэний өгсөн тэр үгэнд Иов итгэлээ тавьж, үхлийн чанадад орших найдлагатай болсон юм.

Бүтээгч Эзэн бүтээлдээ хайртай байх нь жам (Иохан 3:16). Үхээд үгүй болсон бүтээлээ Бүтээгч Эзэн нь саналгүй яах вэ! Өөрийн гараар бүтээсэн хүнээ дахин үзэхийг хүсэлгүй яах вэ!



“Бүх юмсыг хүсэл хийгээд шийдвэрээрээ үйлддэг” Тэрээр Өөрийн “зорилгын дагуу урьдаас тогтоогдсон ёсоор” мөхсөн хүн төрөлхтөнийг товлож тогтоосон цагтаа үхэгсдийн орноос дуудан гаргах болно.

Мутрынхаа бүтээл рүү Бүтээгч Эзэн тэмүүлж, мөхсөн бүхнийг дахин амилуулна. Үхэгсдийг амилуулах нь Бүтээгч Эзэний бүтээх хамгийн агуу хүч чадлын үйл билээ (Эфэс 1:11,19-20). □

Аврагч Эзэн нь амьд гэсэн бат итгэл Иовд байтугай бидэнд мөн адил үхлийн чанадад орших найдлага өгсөнийг дараагийн нийтлэлд авч үзэх болно.



Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Johnson, K. (2017). Ancient Testaments of the Patriarchs: Autobiographies from the Dead Sea scrolls.

---Септуагинта хэмээх эртний грек орчуулга (МЭӨ 3-1-р зуун). LXX гэж товчилдог. www.blueletterbible.org

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org